ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Алтанширээ сумын эрүүл мэндийн төвийн
2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: ДГА-2023/88/НА-СТА-ТШЗ**


Цахим хуудас: www.dornogovi@audit.gov.mn

Дорноговь аймаг

Сайншанд сум

2023 он

Дарга, Тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий

Утас: 261665, 70522734
Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn

Аудитын менежер: У.Оюунтүлхүүр
Утас:70523020
Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn

Аудитор: Т.Оюунтуяа
Утас: 99048991

Цахим хаяг: oyuntuya@esanhuu.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (705) 2-27-34
Цахим хуудас: dornogovi@audit.gov.mn

2023.02.24 № 1-6/230

танай ______ -ны № ______ -т

АЛТАНШИРЭЭ СУМЫН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА
Д.БОЛОРЧИМЭГ ТАНАА

## Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Алтаннширээ сумын эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.
Дорноговь аймгийн Алтанширээ сумын эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд тус байгууллагын үйл ажиллагаанд асуудлын онцлох хэсэгт дурдах асуудал илрээгүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн асуудлуудыг авч үзлээ.

Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт орж, эрүүл мэндийн байгууллагуудын даатгалын сангаас төлөх зардлын төлбөрийг тусламж үйлчилгээний гүйцэтгэлээр тооцож, 2021 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн олгох болсон байна.

Илрүүлэлтээр шилэн дансны цахим системд 7 хоногийн хугацаанд оруулбал зохих 605.5 сая төгрөгийн мэдээллүүдээс нийт 372.2 сая төгрөгийн 15 гүйлгээ, 1.7 сая төгрөгийн төсөв, хөрөнгө зарцуулах 3 шийдвэрийг хугацаа хоцроосон, мөн цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 65.8 сая төгрөгийн орлогын 5 гүйлгээ, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш

үнийн дүн бүхий 8.2 сая төгрөгийн зарлагын 1 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө зарцуулах 20.7 сая төгрөгийн 10 шийдвэрийг огт мэдээлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6.4 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:" 6.4.5 "Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", 6.4.8 "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр"; заалтуудтай нийцээгүй байна.

Тайлант хугацааны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийгдэж буй аудитад шаардсан материалуудыг тогтоосон цаг хугацаанд бүрэн гүйцэт гаргаж ирүүлээгүй, аудитын шалгалтын ажилд хүндрэл саад учруулсан бөгөөд энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйл "16.1.1.төрийн аудитын байгууллагын аудит хийхэд шаардагдах цаасан болон цахим хэлбэрийн мэдээлэл, баримт бичгээр хангах, уг мэдээлэл, баримт бичгийн үнэн зөв, бодитой, бүрэн байх шаардлагыг хариуцах; 16.1.3.төрийн аудитын байгууллагын үйл ажиллагаанд саад учруулах, ......, оролцохгүй байх; 16.1.4.төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг бүрэн ирүүлэх; 16.1.6.хуульд заасан бусад үүрэг." заалтуудтай нийцээгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Анхан шатны баримтын тулгалтаар 38 харилцагчдаас 52.6 сая төгрөгийн худалдан авалтад ибаримт аваагүй байна. Энэ нь үнэлгээ ба хуваарилалт, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүйгээс гадна НББ-н тухай хуулийн 3.1.3-д "анхан шатны баримт" гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог; 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтууд, НӨАТ-ын тухай хуулийн 17.3.2-т "бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно"; 17.6-д "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй" гэсэн заалттай нийцэхгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Эд хөрөнгийн тооллого чанартай хийгдээгүй, 2.8 сая төгрөгийн түлш, шатах тослох материалыг тоолоогүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6-д заасан "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэсэн заалттай нийцэхгүй, иж бүрэх байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Бусад асуудлын хэсэг**

2022 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 9 зорилт, 51 арга хэмжээний хэрэгжилт 90.0 хувь, хөтөлбөр, арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөж зарцуулсан төсвийн гүйцэтгэл 90.2 хувийн биелэлттэй байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Т. ГАН-ӨЛЗИЙ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **153,894,012.72** | **151,970,628.39** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 851,324.51 | 42,424,180.51 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 851,324.51 | 42,424,180.51 |
| **3121** | **Төгрөг** | 851,324.51 | 42,424,180.51 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 31,333.11 | 42,424,180.51 |
| 31215 | Нэмэлт санхүүжилтийн харилцах | 819,991.40 | - |
| **33** | **АВЛАГА** | 83,681,100.00 | 12,941,065.15 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | - | 3,888,685.15 |
| **335** | **Бусад авлага** | 83,681,100.00 | 9,052,380.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 83,492,100.00 | 6,596,380.00 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 189,000.00 | 2,456,000.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 69,361,588.21 | 96,605,382.73 |
| **351** | **Түүхий эд материал** | 35,017,854.01 | 60,754,695.74 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 1,810,000.00 | 5,726,503.70 |
| 35130 | Эм боох материал | 33,207,854.01 | 55,028,192.04 |
| 35200 | Дуусаагүй үйлдвэрлэл | 100,000.00 | - |
| **354** | **Хангамжийн материал** | 34,243,734.20 | 35,850,686.99 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 709,500.00 | 2,788,500.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 32,997,984.20 | 29,482,046.99 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 220,800.00 | 2,771,900.00 |
| 35460 | Хүнсний материал | 315,450.00 | 808,240.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **600,543,449.87** | **580,075,458.41** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 600,543,449.87 | 580,075,458.41 |
| **392** | **Биет хөрөнгө** | 588,447,449.87 | 568,342,458.41 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 483,667,784.00 | 483,667,784.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (29,323,885.32) | (40,805,442.00) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 72,799,990.00 | 72,799,990.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (25,848,323.34) | (45,621,656.70) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 128,130,998.56 | 133,652,429.85 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (77,998,301.33) | (79,567,428.00) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 22,340,097.00 | 35,377,136.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (12,939,609.45) | (16,266,922.10) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 30,728,916.00 | 29,578,116.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (3,110,216.25) | (4,471,548.64) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 12,096,000.00 | 11,733,000.00 |
| 39301 | Програм хангамж | 1,727,000.00 | 1,727,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (363,000.00) | (726,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 10,732,000.00 | 10,732,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **754,437,462.59** | **732,046,086.80** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **9,478,907.40** | **-** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 9,478,907.40 | - |
| **413** | **Өглөг** | 9,478,907.40 | - |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 9,478,907.40 | - |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **744,958,555.19** | **732,046,086.80** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 744,958,555.19 | 732,046,086.80 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 214,812,011.44 | 214,812,011.44 |
| 51101 | Өмч: - төрийн | 214,812,011.44 | 214,812,011.44 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 137,920,383.92 | 125,007,915.53 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 137,920,383.92 | 137,920,383.92 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (12,912,468.39) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 392,226,159.83 | 392,226,159.83 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **754,437,462.59** | **732,046,086.80** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **740,853,614.17** | **514,013,341.65** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **232,554,953.68** | **70,843,169.65** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 232,554,953.68 | 70,843,169.65 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө | 70,186,973.56 | 27,018,360.29 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал | 162,367,980.12 | 43,824,809.36 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **508,298,660.49** | **443,170,172.00** |

| | | | |
|---|---|---|---|
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 309,103,635.00 | - |
| 131003 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 387,335.00 | - |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 308,716,300.00 | - |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 149,997,703.45 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 23,200,000.00 | - |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 14,699,203.45 | - |
| 131107 | Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого | 112,098,500.00 | |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 37,488,792.04 | 49,201,492.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 37,488,792.04 | 49,201,492.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 11,708,530.00 | 393,968,680.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 11,708,530.00 | 393,968,680.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **602,380,515.52** | **525,199,688.94** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **602,380,515.52** | **525,199,688.94** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 579,180,515.52 | 525,199,688.94 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 228,551,413.00 | 260,099,216.23 |
| 210101 | Үндсэн цалин | 138,131,437.00 | 175,848,368.23 |
| 210102 | Нэмэгдэл | 78,594,937.00 | 72,683,006.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 2,622,000.00 | 3,163,000.00 |
| 210104 | Урамшуулал | 9,203,039.00 | 8,404,842.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 30,336,100.00 | 30,488,913.62 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 21,547,100.00 | 20,999,290.42 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,197,700.00 | 2,372,380.80 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,757,700.00 | 1,898,084.83 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 439,400.00 | 474,196.97 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,394,200.00 | 4,744,960.60 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 36,427,292.04 | 38,879,847.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,733,994.04 | 2,182,969.00 |
| 210302 | Түлш, халаалт | 34,070,190.00 | 34,070,189.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 623,108.00 | 2,626,689.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 29,145,171.09 | 45,264,524.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,712,750.00 | 5,734,450.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 16,967,390.00 | 18,190,500.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,203,187.09 | 1,226,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 880,644.00 | 396,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 115,100.00 | 19,717,574.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 8,266,100.00 | - |
| **2105** | **Нормативт зардал** | 182,721,869.32 | 73,670,701.44 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 176,999,272.32 | 67,013,869.44 |
| 210502 | Хоол, хүнс | 5,722,597.00 | 6,656,832.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,179,970.00 | 7,382,413.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 32,280.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 2,147,690.00 | 7,382,413.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 378,000.00 | 1,378,400.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 378,000.00 | 1,378,400.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 16,487,630.45 | 1,967,463.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 15,837,008.45 | 1,098,500.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 480,000.00 | 360,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 54,450.00 | 150,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 105,000.00 | 133,950.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | - | 225,013.00 |
| 210807 | Газрын төлбөр | 11,172.00 | - |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 52,953,069.62 | 66,068,210.65 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,865,150.00 | 4,788,780.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 50,087,919.62 | 61,279,430.65 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 23,200,000.00 | - |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 23,200,000.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 23,200,000.00 | - |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **138,473,098.65** | **(11,186,347.29)** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 4,021,789.46 | 1,726,121.10 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 1,543,489.46 | 1,726,121.10 |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 2,478,300.00 | - |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | (4,021,789.46) | (1,726,121.10) |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **134,451,309.19** | **(12,912,468.39)** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **424,864,060.49** | **520,065,892.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **424,864,060.49** | **520,065,892.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 308,716,300.00 | - |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 308,716,300.00 | - |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 66,950,438.45 | 83,492,100.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 23,200,000.00 | - |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 15,086,538.45 | 83,492,100.00 |
| 131107 | Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого | 28,663,900.00 | |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 37,488,792.04 | 49,201,492.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 37,488,792.04 | 49,201,492.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 11,708,530.00 | 387,372,300.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 11,708,530.00 | 387,372,300.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **418,574,735.98** | **462,973,836.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **418,574,735.98** | **462,973,836.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **395,374,735.98** | **462,973,836.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 228,551,413.00 | 263,979,801.00 |
| 210101 | Үндсэн цалин | 138,131,437.00 | 180,313,489.00 |
| 210102 | Нэмэгдэл | 78,594,937.00 | 72,098,470.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 2,712,000.00 | 3,163,000.00 |
| 210104 | Урамшуулал | 9,113,039.00 | 8,404,842.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 30,336,100.00 | 30,497,014.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 21,547,100.00 | 21,007,391.12 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,197,700.00 | 2,372,380.72 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,757,700.00 | 1,898,084.58 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 439,400.00 | 474,197.14 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,394,200.00 | 4,744,960.44 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 36,427,292.04 | 38,879,847.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,733,994.04 | 2,182,969.00 |
| 210302 | Түлш, халаалт | 34,070,190.00 | 34,070,189.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 623,108.00 | 2,626,689.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 20,391,731.09 | 26,955,750.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,752,200.00 | 3,999,450.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 14,595,700.00 | 20,064,500.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,203,187.09 | 1,146,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,940,644.00 | 396,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 900,000.00 | 1,349,800.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 56,190,529.40 | 67,830,636.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 48,989,982.40 | 59,290,864.00 |
| 210502 | Хоол, хүнс | 5,200,547.00 | 6,762,272.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,000,000.00 | 1,777,500.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 3,476,890.00 | 26,408,795.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,180,000.00 | 25,000.00 |
| 210602 | Тавилга | - | 2,000,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 70,000.00 | 2,570,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,226,890.00 | 21,813,795.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 378,000.00 | 1,378,400.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 378,000.00 | 1,378,400.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 16,487,630.45 | 1,813,463.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 15,837,008.45 | 944,500.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 480,000.00 | 360,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 54,450.00 | 150,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 105,000.00 | 133,950.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | - | 201,287.00 |
| 210807 | Газрын төлбөр | 11,172.00 | 23,726.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 3,135,150.00 | 5,230,130.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,135,150.00 | 5,230,130.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **23,200,000.00** | **-** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 23,200,000.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 23,200,000.00 | - |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **6,289,324.51** | **57,092,056.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **6,426,000.00** | **15,519,200.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **6,426,000.00** | **15,519,200.00** |

| | | | |
|---|---|---|---|
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 6,426,000.00 | 15,519,200.00 |
| 222001 | Тоног төхөөрөмж | 988,000.00 | 3,401,700.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 5,438,000.00 | 12,117,500.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(6,426,000.00)** | **(15,519,200.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | (136,675.49) | 41,572,856.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | 851,324.51 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | 42,424,180.51 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C08 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **214,812,011.44** | **392,226,159.83** | **137,920,383.92** | 744,958,555.19 |
| D01 | **2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **214,812,011.44** | **392,226,159.83** | **137,920,383.92** | 744,958,555.19 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **214,812,011.44** | **392,226,159.83** | **137,920,383.92** | 744,958,555.19 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | (12,912,468.39) | (12,912,468.39) |
| D09 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **214,812,011.44** | **392,226,159.83** | **125,007,915.53** | 732,046,086.80 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | |
|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 530,306,700.00 | 478,493,036.00 | 51,813,664.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 530,306,700.00 | 478,493,036.00 | 51,813,664.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 530,306,700.00 | 478,493,036.00 | 51,813,664.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 280,971,700.00 | 263,979,801.00 | 16,991,899.00 |
| 210101 | Үндсэн цалин | 191,293,700.00 | 183,171,639.00 | 8,122,061.00 |
| 210102 | Нэмэгдэл | 69,566,000.00 | 69,240,320.00 | 325,680.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 4,752,000.00 | 3,163,000.00 | 1,589,000.00 |
| 210104 | Урамшуулал | 15,360,000.00 | 8,404,842.00 | 6,955,158.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 39,536,200.00 | 30,497,014.00 | 9,039,186.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 28,564,600.00 | 21,007,391.12 | 7,557,208.88 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,742,900.00 | 2,372,380.72 | 370,519.28 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,194,300.00 | 1,898,084.58 | 296,215.42 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 548,600.00 | 474,197.14 | 74,402.86 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,485,800.00 | 4,744,960.44 | 740,839.56 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 38,958,300.00 | 38,879,847.00 | 78,453.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,341,400.00 | 2,182,969.00 | 158,431.00 |
| 210302 | Түлш, халаалт | 34,070,200.00 | 34,070,189.00 | 11.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,546,700.00 | 2,626,689.00 | (79,989.00) |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 31,721,800.00 | 26,955,750.00 | 4,766,050.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 5,021,000.00 | 3,999,450.00 | 1,021,550.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 22,890,800.00 | 20,064,500.00 | 2,826,300.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,200,000.00 | 1,146,000.00 | 54,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,200,000.00 | 396,000.00 | 804,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,410,000.00 | 1,349,800.00 | 60,200.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 72,956,900.00 | 67,830,636.00 | 5,126,264.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 62,742,900.00 | 59,290,864.00 | 3,452,036.00 |
| 210502 | Хоол, хүнс | 7,500,000.00 | 6,762,272.00 | 737,728.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,714,000.00 | 1,777,500.00 | 936,500.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 56,210,000.00 | 41,927,995.00 | 14,282,005.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 2,500,000.00 | 663,000.00 | 1,837,000.00 |
| 210602 | Тавилга | 16,200,000.00 | 15,166,200.00 | 1,033,800.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 3,570,000.00 | 2,570,000.00 | 1,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 33,940,000.00 | 23,528,795.00 | 10,411,205.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,445,200.00 | 1,378,400.00 | 66,800.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,445,200.00 | 1,378,400.00 | 66,800.00 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,664,800.00 | 1,813,463.00 | 851,337.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,298,000.00 | 944,500.00 | 353,500.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 774,000.00 | 360,000.00 | 414,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 150,600.00 | 150,000.00 | 600.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 134,000.00 | 133,950.00 | 50.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 202,600.00 | 201,287.00 | 1,313.00 |
| 210807 | Газрын төлбөр | 105,600.00 | 23,726.00 | 81,874.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 5,841,800.00 | 5,230,130.00 | 611,670.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5,841,800.00 | 5,230,130.00 | 611,670.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 530,306,700.00 | 520,065,892.00 | 10,240,808.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 53,958,300.00 | 49,201,492.00 | 4,756,808.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 53,958,300.00 | 49,201,492.00 | 4,756,808.00 |
| **1340** | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 476,348,400.00 | 470,864,400.00 | 5,484,000.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 476,348,400.00 | 470,864,400.00 | 5,484,000.00 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | **851,324.51** | (851,324.51) |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | **42,424,180.51** | (42,424,180.51) |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 17.00 | 16.00 | 1.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 | - |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 11.00 | 11.00 | - |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 5.00 | 4.00 | 1.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **-** | **84,312,091.40** |
| 213305 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг | | 84,312,091.40 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | - | 83,492,100.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | - | 83,492,100.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 83,492,100.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 819,991.40 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 82.7 сая төгрөгийн 5 алдаа[1] илэрснээс аудитын явцад 82.7 сая төгрөгийн 5 алдааг залруулллаа.

**Залруулсан алдаа:**

1. 2022 оны 11, 12 сарын нэг иргэний нормативт санхүүжилтийн 20 хувь болох 6.5 сая төгрөгийг авлагаар бүртгээгүй байсан алдааг залруулсан.
2. Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг 3.5 сая төгрөгөөр дутуу тооцсоныг залруулсан.
3. Санхүү тайланд ХХОАТ-ын 0.4 сая төгрөгийн авлага, суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан албан татварын 3.5 сая төгрөгийн авлага, нийгмийн даатгалын 0.008 сая төгрөгийн авлага тус тус бүртгэгдээгүй байсныг залруулсан.
4. ИТХ-ын тогтоолоор хөрөнгө хасахдаа 0.3 сая төгрөгөөр дутуу хассаныг залруулсан.
5. Үнэ төлбөргүй авсан 24.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 43.8 сая төгрөгийн бараа материалыг тус тус бүртгээгүй байсныг залруулсан.

Аудитаар нийт 4 зөрчил[2] илэрснээс, 1 албан шаардлага, 1 хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлж, 2 зөвлөмж өгсөн.

### 3.2 Албан шаардлага

**1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

Тус байгууллагын Шилэн дансны цахим системд 7 хоногийн хугацаанд оруулбал зохих 605.5 сая төгрөгийн мэдээллүүдээс нийт 372.2 сая төгрөгийн 15 гүйлгээ, 1.7 сая төгрөгийн төсөв, хөрөнгө зарцуулах 3 шийдвэрийг хугацаа хоцроосон, мөн цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 65.8 сая төгрөгийн орлогын 5 гүйлгээ, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 8.2 сая төгрөгийн зарлагын 1 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө зарцуулах 20.7 сая төгрөгийн 10 шийдвэрийг огт мэдээлээгүй байна. Энэ нь төсөв, өмч, хөрөнгө, мөнгө шамшигдуулах, орлого нуун дарагдуулах, зориулалтын бус, үр ашиггүй зарцуулалт хийгдэх үр дагавартай.

Мөн Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 “Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6.4 “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:” 6.4.5 “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, 6.4.8 “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр”; заалтуудтай нийцээгүй байна.

**2. Шалгагдагч байгууллагын хуулиар хүлээсэн үүрэгтэй холбоотой асуудал**

Тайлант хугацааны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийгдэж буй аудитад шаардсан материалуудыг тогтоосон цаг хугацаанд бүрэн гүйцэт гаргаж ирүүлээгүй, аудитын шалгалтын ажилд хүндрэл саад учруулсан бөгөөд энэ нь аудитын тайлан хугацаа хоцрох, хэрэглэгчид бодитой мэдээллээр хангагдаж чадахгүй байх, хууль хэрэгжихгүй байх үр дагавартай.

Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйл “16.1.1.төрийн аудитын байгууллагын аудит хийхэд шаардагдах цаасан болон цахим хэлбэрийн мэдээлэл, баримт бичгээр хангах, уг мэдээлэл, баримт бичгийн үнэн зөв, бодитой, бүрэн байх шаардлагыг хариуцах; 16.1.3.төрийн аудитын байгууллагын үйл ажиллагаанд саад учруулах, ......, оролцохгүй байх; 16.1.4.төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл,

---

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

баримт бичгийг бүрэн ирүүлэх; 16.1.6.хуульд заасан бусад үүрэг.” заалтуудтай нийцээгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**3.3 Зөвлөмж**

1. **Төлбөрийн цахим баримттай холбоотой асуудал**

<u>*Илрүүлэлт:*</u> Анхан шатны баримтын тулгалтаар 38 харилцагчдаас 52.6 сая төгрөгийн худалдан авалтад ибаримт аваагүй байна. Энэ нь төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах үр дагавартай

Мөн үнэлгээ ба хуваарилалт, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүйгээс гадна НББ-н тухай хуулийн 3.1.3-д “анхан шатны баримт” гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог; 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтууд, НӨАТ-ын тухай хуулийн 17.3.2-т "бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно"; 17.6-д "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй" гэсэн заалттай нийцэхгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

<u>*Өгсөн зөвлөмж:*</u> Худалдан авалтыг тооцоо хийгдсэн тухай бүрд нь цаасан болон цахим ибаримтыг үндэслэн санхүүгийн тайланд тусгаж ажиллах

2. **Дотоод хяналттай холбоотой асуудал**

<u>*Илрүүлэлт*</u>: Эд хөрөнгийн тооллого чанартай хийгдээгүй, 2.8 сая төгрөгийн түлш, шатах тослох материалыг тоолоогүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6-д заасан “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;” гэсэн заалттай нийцэхгүй, иж бүрэх байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

<u>*Өгсөн зөвлөмж:*</u> Хөрөнгийн тооллогыг бодитой, чанартай хийж, тооллогын үр дүнгээр холбогдох мэдээллүүдийг тодорхой тусгаж /хэзээ, ямар дансыг, аль өдрийн үлдэгдлээр тоолсон эсэх/, акт үйлдэж байх.

Дээрх зөвлөмж, албан шаардлагын биелэлтүүдийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 2022 оны 11, 12 сарын нэг иргэний нормативт санхүүжилтийн 20 хувь болох 6.5 сая төгрөгийг авлагаар бүртгээгүй байсныг залруулсан | 1 | 6,533.9 | 0 | - | 1 | 6,533.9 | 1 | 6,533.9 | 0 | - | | |
| Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг 3.5 сая төгрөгөөр дутуу тооцсоныг залруулсан | 1 | 3,547.4 | 0 | - | 1 | 3,547.4 | 1 | 3,547.4 | 0 | - | | |
| Санхүү тайланд ХХОАТ-ын 0.4 сая төгрөгийн авлага, суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан албан татварын 3.5 сая төгрөгийн авлага, нийгмийн даатгалын 0.008 сая төгрөгийн авлага тус тус бүртгэгдээгүй байсныг залруулсан | 1 | 3,888.7 | 0 | - | 1 | 3,888.7 | 1 | 3,888.7 | 0 | - | | |
| ИТХ-ын тогтоолоор хөрөнгө хасахдаа 0.3 сая төгрөгөөр дутуу хассаныг залруулсан. | 1 | 344.1 | 0 | - | 1 | 344.1 | 1 | 344.1 | 0 | - | | |
| Үнэ төлбөргүй авсан 24.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 43.8 сая төгрөгийн бараа материалыг тус тус бүртгээгүй байсныг залруулсан | 1 | 68,568.1 | 0 | - | 1 | 68,568.1 | 1 | 68,568.1 | 0 | - | | |
| **Дүн** | **5** | **82,882.2** | **-** | **-** | **5** | **82,882.2** | **5** | **82,882.2** | **-** | **-** | | |

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Тайлант хугацааны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийгдэж буй аудитад шаардсан материалуудыг тогтоосон цаг хугацаанд бүрэн гүйцэт гаргаж ирүүлээгүй, аудитын шалгалтын ажилд хүндрэл саад учруулсан | 1 | | | | | | | | 1 | 2 | | |
| Анхан шатны баримтын тулгалтаар 38 харилцагчдаас 52.6 сая төгрөгийн худалдан авалтад ибаримт аваагүй байна. | 1 | | | | | | 1 | | | | | |
| 2.8 сая төгрөгийн түлш, шатах тослох материалыг тоолоогүй байна. | 1 | | | | | | 1 | | | | | |
| Дүн | 3 | | | | | | 2 | | 1 | | | |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| **Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил** | | | | | | | | |
| Тус байгууллагын Шилэн дансны цахим системд 7 хоногийн хугацаанд оруулбал зохих 605.5 сая төгрөгийн мэдээллүүдээс нийт 372.2 сая төгрөгийн 15 гүйлгээ, 1.7 сая төгрөгийн төсөв, хөрөнгө зарцуулах 3 шийдвэрийг хугацаа хоцроосон, мөн цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 65.8 сая төгрөгийн орлогын 5 гүйлгээ, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 8.2 сая төгрөгийн зарлагын 1 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө зарцуулах 20.7 сая төгрөгийн 10 шийдвэрийг огт мэдээлээгүй байна. | 1 | | | | 1 | | | |
| **Дүн** | **1** | | | | **1** | | | |